

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/23

Сүмбэр сум

Орон нутгийн хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, нөхцөл байдлыг үнэлэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг “Хүүхэд хамгааллын даатгал”-д хамруулах үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, 18.2.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.4, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.3, 42.1, Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан Онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан Коронавируст халдвар /ковид-19/ цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 дугаар зүйлийн 5.6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, нөхцөл байдлыг үнэлэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг “Хүүхэд хамгааллын даатгал”-д хамруулах үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажиллахыг Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн, Хүүхдийн эрхийн улсын байцаагч (Б.Шархүү)-д үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 621 500 (зургаан зуун хорин нэгэн мянга таван зуу) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА




Ц.ОЮУНБИЛЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал

1270040

ГБХЗХГазрын даргын 2021 оны  
03 сарын 24-ний өдрийн 4/23  
дугаар тушаалын 1-р хавсралт



**ОРОН НУТГИЙН ХҮҮХДҮҮДИЙГ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛЭН,  
ЭРСДЭЛТ НӨХЦӨЛЦ БАЙГАА ХҮҮХДҮҮДИЙГ “ХҮҮХЭД  
ХАМГААЛЛЫН ДААТГАЛ”-Д ХАМРУУЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**НЭГ. Үндэслэл**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, 18.2.1 дүгээр зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.4 дүгээр зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1.3, 42.1 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах.

**ХОЁР. Зорилго**

Хүүхдийн эрх, хамгаалал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, “Хүүхэд хамгаалал”-ын даатгалын үйлчилгээнд хамруулан учирч болзошгүй эрсдэлийн нөлөөг бууруулах.

**ГУРАВ. Хугацаа**

2021-02-18-аас 2021-03-04

**ДӨРӨВ. Хамрах хүрээ**

Сумдын хамтарсан багаас ирүүлсэн өндөр эрсдэл бүхий хүүхдүүдийн судалгаанд үндэслэн /Сүмбэр сумын 236 хүүхэд, Шивээговь сумын 96 хүүхэд, Баянтал сумын 54/ тухайн хүүхдүүдээс эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийж даатгалд хамрагдах шаардлагатай хүүхдүүдийг үйлчилгээнд хамруулна.

**ТАВ. Хамтран ажиллах байгууллага**

Сумдын хамтарсан баг


**ЗУРГАА. Зохион байгуулалт**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллага
1	НБҮ болон Гэр бүлийн нөхцөл байдал, хэрэгцээний үнэлгээг сонгогдсон өрхүүдээс авах	2021.02.19	ХЭХМ, ХЭУБ Б.Шархүү, Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг, Бичиг хэрэг Б.Урансанаа, Жолооч Ц.Болдбаатар	Сумдын хамтарсан баг



152

ГБХЗХГазрын даргын 2021 оны  
03 сарын 24-ний өдрийн 223  
дугаар тушаалын 2-р хавсралт



**ОРОН НУТГИЙН ХҮҮХДҮҮДИЙГ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭН  
ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ**

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	литр	50	1'510	75'500
2	Томилолт	ш	4	26'500	106'000
3	Хүүхэд хамгааллын даатгал	хүүхэд	6	45'000	270'000
4	Хүртээмжтэй даатгал	Хүүхэд	34	5'000	170'000
<b>Нийт төсөв</b>					<b>621'500</b>

Боловсруулсан: Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн  
Хүүхдийн эрхийн улсын байцаагч *В.Шархүү* Б.Шархүү